

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦСАН:  
401 ДҮГЭЭР ХААЛТАЙ ХОРИХ АНГИ-НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА, ХУРАНДАА

Д.ТУЛГА

## ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ХАРЬЦУУЛАЛТЫН ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Шатахуун

Төслийн дугаар: ХХАНЭ401/202001001

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

## УРИЛГА

**2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр**

**Харьцуулалтын үнийн саналын шалгаруулалтын нэр: "Шатахуун нийлүүлэх"  
Харьцуулалтын үнийн саналын шалгаруулалтын дугаар: ХХАНЭ401/202001001**

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь эрх бүхий оролцогчдоос шатахуун нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Сонирхсон этгээд баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Үнийн саналыг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11цаг 30 минутад нээнэ.

**Монгол, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо  
ШШГЕГ-ын харъяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг өөрийн байр,  
Утас: 85180401, 92145005  
Имэйл хаяг: tamir\_uu@yahoo.com**

## **НЭГ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл

шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## ХОЁР. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТОӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<p>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны баталгаажсан санхүүгийн тайланг ирүүлэх.</p> <p>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох, гэрээ, гэрээ дүгнэсэн актийн хуулбарыг ирүүлэх.</p> <p>2018, 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.</p> <p>Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг дахь шатахуун түгээх станцуудын байршил, хүчин чадал, үйлчилгээний үнийн тарифыг газрын байршилаар ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Бүх төрлийн шатахуун шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, бөөнөөр болон жижиглэнгээр худалдаалах тусгай зөвшөөрөлтэй байх</li> <li>➤ Барааны гарал үүслийн гэрчилгээ</li> <li>➤ Татварын цахим тодорхойлолт ирүүлэх</li> <li>➤ Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>➤ Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>➤ Нийлүүлэх бараа нь чанар стандартын шаардлага хангасныг нотлох мэргэжлийн хяналтын байгууллагын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг, дүгнэлт</li> <li>➤ Нийлүүлэх явцад шатахууны чанарын үзүүлэлт /октан-/ыг 2-оос доошгүй удаа шалгуулахад татгалзах зүйлгүйг зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх</li> <li>➤ Эрх бүхий тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүйг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх.</li> <li>➤ Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тендерийн үнэ тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</li> </ul>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p><b>Үнийн санал хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b>  <b>Байгууллагын хаяг:</b> Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 10-р хороо  <b>Давхар болон өрөөний дугаар:</b> 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2 давхарт санхүүгийн алба  <b>Огноо:</b> 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр  <b>Цаг:</b> 11 цаг 00 минут</p>
<b>ТОӨЗ 2.2</b>	<p><b>Тендер нээх эцсийн хугацаа:</b>  <b>Байгууллагын хаяг:</b> Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 10-р хороо  <b>Давхар болон өрөөний дугаар:</b> 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2 давхарт санхүүгийн алба  <b>Огноо:</b> 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр  <b>Цаг :</b> 11 цаг 30 минутад нээнэ.</p>

<b>ТӨӨ3 3.1</b>	Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 3 хоногоос багагүй байна.
<b>ТӨӨ3 3.2</b>	Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх бичиг баримт нь <b>Монгол хэл дээр</b> байна.
<b>ТӨӨ3 3.3</b>	Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”
<b>ТӨӨ3 6.2</b>	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</b></p> <p>Багц №1. Шатахуун Багц №2. Тос, тослох материал</p>

## ГУРАВ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Нийлүүлэгч нь хамгийн бага үнээр улирлын нөхцөлд тохирсон 2 төрлийн / АИ-92, дизель түлш/ шатахууныг худалдан авагч талд жилийн туршид бэлэн бус хэлбэрээр /Шатахууны талон, карттай байх/ олгох.
- Нийлүүлэх авто шатахуун нь ОХУ-ын ГОСТ Р 51105-97 стандартын дагуу үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц чанар стандартыг хангасан байна. Өөр гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тохиолдолд тухайн барааг үйлдвэрлэсэн стандарт нь Монгол улсын MNS 216:2006, MNS 217:2006 стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ.
- Нийлүүлэгдэх бараа “АИ-92, ДТ” нь үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлнэ. Холбогдох стандартад нийцэж байгаа болон түүнээс илүүгээр хангаж байгааг харуулсан дагалдах бичгүүдийг заавал хавсаргана.
- ШТС-ийн салбарууд нь хөдөө орон нутгийн 21 аймагт салбартай байх.
- ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгтэй ойр байх. /ШТС – уудын хаяг, байршилыг харуулсан газрын зураг хавсаргах/

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэм жих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермиийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүү лэх эцсийн хугацаа	Нийлүү лэгчийн санал болгосо н хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	АИ-92	7100	Литр	401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт	2020 оны 02 сараас	2020 оны 12 сар дуустал	
2	Дизель түлш	12000	Литр				
3	Тос тослох материал	248.75	Литр				

## Багц №1. ШАТАХУУН

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Сарын нийлүүлэлтийн хуваарь												Нийлүүлэх тоо хэмжээ	
			Литр	1cap	2cap	3cap	4cap	5cap	6cap	7cap	8cap	9cap	10cap	11cap	12cap	
1	АИ 92 бензин		580	580	580	580	580	600	600	600	600	600	600	600	600	7100
2	Дизель түлш	Литр	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	1000	12000

## Багц №2. ТОС, ТОСЛОХ МАТЕРИАЛ

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Сарын нийлүүлэлтийн хуваарь												Нийлүүлэх тоо хэмжээ
			1cap	2cap	3cap	4cap	5cap	6cap	7cap	8cap	9cap	10cap	11cap	12cap	
1	Тос, масло	Литр	20	20	20	20	24	20	20	20	20	24	20	20.75	248.75

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэ г	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тэндерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[too]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан too]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үргээ билэлүүлээгү</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үргээ билэлүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа

**й-гээс  
гэрээг  
цуцлах**

хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биөлэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>	1.1 Шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>	"Монгол улсын гаднаас санал болгосон бараа: Incoterms 2010 DDP" Шатахууныг жилийн туршид тасралтгүй хангах бөгөөд зах зээл дээр шатахууны хомсдол гарсан нөхцөлд гэрээт байгууллагын үйл ажиллагааг зохих түвшинд хангах шатахууны нөөцтэй байх.
<b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>	401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхэлж буй машин техникт "24" цагийн турш очер дараалалгүй үйлчлэх.  Байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ  Барааны гарал үүслийн гэрчилгээ
<b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>	5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө. 5.2 Үйлчилгээний явцад шатахууны төрлийг андуурч олгосноос үүдэлтэй техникт гарсан эвдрэлийг нийлүүлэгч тал хариуцна гэсэн мэдэгдэл ирүүлэх 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ. 1. <b>Урьдчилгаа төлбөр:</b> Байхгүй 2. <b>Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</b> Байхгүй. 3. <b>Барааг хүлээн авахад төлөх төлбөр:</b> 100 хувь / Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө. 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5% Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.
<b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>	

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>3</sup>

Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.